НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын Хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/555/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Утас: 327734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр<br>Утас: 325093 Цахим хаяг: Munkhdelgerd@audit.gov.mn<br>Аудитор: Б.Тэгшлхам<br>Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn |
| OBJ OBJ | OBJ OBJ |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....................................4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА........................................................................12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........................................................................12
**4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**.............12
**5. Дараагийн аудитаар анхаарах асуудал:** ..........................................................13
**6. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**..........................................................................................13
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..........................................14

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 8 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.05 № 64

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА М.МЯГМАР-ОЧИР ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийслэлийн Онцгой комиссоос 33.4 сая төгрөг, Соёл урлагийн газраас 0.2 сая төгрөг, дүүргийн ИТХ-аас 55.0 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 64.3 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 7.8 сая төгрөг, нийт 160.7 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 160.2 сая төгрөг зарцуулж, 0.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

14260958141

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 3,631.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,089.4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй олгосон байна.

**Бусад асуудал**

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Бусан хотын Үндэсний аврах тусгай албаны сургагч багш нар "Урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагаа" сэдэвт хээрийн дадлага, онолын сургалтыг Туул гол хар усан тохойд 5 өдөр зохион байгуулж, гал сөнөөгч нийт 54 алба хаагчийг хамруулан сургаж дадлагажуулан амжилттай оролцсон байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.
Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тод руулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,861,201,352.21** | **2,117,848,588.64** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **4.0** | 00.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | **5.0** | 29,455,181.60 | 549,711.86 |
| **335** | **Бусад авлага** | | 29,455,181.60 | 549,711.86 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 28,504,130.96 | 549,711.86 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | | 951,050.64 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6.0** | 1,831,746,170.61 | 2,117,298,876.78 |
| **351** | **Түүхий эд материал** | | 1,160,551,722.52 | 1,902,853,419.90 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 1,160,066,722.52 | 1,902,598,419.90 |
| 35130 | Эм боох материал | | 485,000.00 | 255,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | 354,591,326.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | | 316,603,122.09 | 214,445,456.88 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 20,742,145.00 | 18,977,497.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 18,013,929.00 | 15,820,289.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 52,732,872.00 | 74,369,919.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 47,513,383.03 | 4,623,646.52 |
| 35450 | Барилгын засварын материал | | 66,963,484.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | | 13,184,778.70 | 2,576,775.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 97,452,530.36 | 98,077,330.36 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **6,614,349,907.03** | **8,636,133,247.32** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7.0** | 6,614,349,907.03 | 8,636,133,247.32 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 6,371,851,087.03 | 8,393,634,427.32 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 2,501,673,202.97 | 2,870,673,202.97 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | -413,418,374.82 | -490,964,709.06 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 10,085,253,724.88 | 11,750,461,682.88 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | -6,209,379,478.88 | -6,162,284,738.02 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 781,413,261.65 | 861,087,708.17 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | -417,024,144.90 | -470,672,698.54 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 85,046,316.69 | 85,046,316.69 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | -41,713,420.56 | -49,712,337.77 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 242,498,820.00 | 242,498,820.00 |
| 39301 | Програм хангамж | | 900,000.00 | 900,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | -900,000.00 | -900,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **8,475,551,259.24** | **10,753,981,835.96** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **00.00** | **267,080.74** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | 00.00 | 267,080.74 |
| **413** | **Өглөг** | **9.0** | 00.00 | 267,080.74 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 00.00 | 267,080.74 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **8,475,551,259.24** | **10,753,714,755.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 8,475,551,259.24 | 10,753,714,755.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 768,679,288.10 | 768,679,288.10 |
| 51101 | Өмч: - төрийн | | 768,679,288.10 | 768,679,288.10 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 7,037,136,518.58 | 9,315,300,014.56 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 7,037,136,518.58 | 7,037,136,518.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 00.00 | 2,278,163,495.98 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 669,735,452.56 | 669,735,452.56 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **8,475,551,259.24** | **10,753,981,835.96** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тод-руулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2.0** | **5,511,454,696.88** | **9,175,792,750.83** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **1,850,582,103.80** | **5,168,512,753.83** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 1,850,582,103.80 | 5,168,512,753.83 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө | | 22,247,000.00 | 3,631,289,904.52 |
| 120004 | Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал | | 839,418,063.80 | 1,072,184,707.8 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 988,917,040.00 | 465,038,141.43 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **3,660,872,593.08** | **4,007,279,997.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 3,377,039,500.00 | 3,846,544,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 3,377,039,500.00 | 3,846,544,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 283,833,093.08 | 160,735,797.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 220,895,713.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 49,332,610.00 | 64,255,272.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 13,604,770.08 | 96,480,525.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3.0** | **4,905,706,362.67** | **5,976,392,290.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **4,905,706,362.67** | **5,976,392,290.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 4,846,320,762.09 | 5,964,962,025.65 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 2,809,291,949.36 | 3,332,366,995.14 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,806,059,700.00 | 1,990,665,195.14 |
| 210102 | Нэмэгдэл | | 811,240,500.00 | 1,200,998,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 191,991,749.36 | 13,639,700.00 |
| 210104 | Урамшуулал | | 00.00 | 127,063,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 59,791,700.00 | 66,190,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 1,403,800.00 | 14,743,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 165,000.00 | 173,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 82,400.00 | 88,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 82,500.00 | 3,191,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 58,058,000.00 | 47,993,200.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 236,695,286.32 | 245,523,955.96 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 94,968,565.25 | 96,814,306.14 |
| 210302 | Түлш, халаалт | | 123,652,165.47 | 128,103,313.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 18,074,555.60 | 20,606,336.42 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 154,115,816.05 | 168,392,452.91 |
| 210401 | Бичиг хэрэг | | 16,203,204.00 | 15,169,544.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 100,046,384.97 | 142,591,608.91 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,850,500.00 | 772,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 2,254,800.00 | 3,013,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3,533,350.00 | 00.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 30,250.00 | 5,483,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 30,197,327.08 | 1,362,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 251,112,921.30 | 720,602,335.10 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 21,206,100.00 | 22,195,350.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 130,308,171.30 | 180,475,739.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 99,598,650.00 | 517,931,246.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 85,971,571.00 | 111,407,607.50 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 2,650,467.00 | 4,318,848.50 |
| 210604 | Урсгал засвар | | 83,321,104.00 | 107,088,759.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 39,383,338.00 | 36,331,960.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | 17,378,316.00 | 36,331,960.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | 22,005,022.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 37,292,981.50 | 106,385,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 32,301,600.00 | 96,938,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 1,850,647.50 | 6,358,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 803,000.00 | 799,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 791,000.00 | 130,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 1,546,734.00 | 2,159,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 1,172,665,198.56 | 1,177,760,219.04 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 50,975,791.90 | 9,557,718.99 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 24,718,220.00 | 3,517,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 1,096,971,186.66 | 1,164,684,600.05 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 59,385,600.58 | 11,430,264.98 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 59,299,620.00 | 7,254,700.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | 00.00 | 7,054,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 59,299,620.00 | 200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 00.00 | 4,175,564.98 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 00.00 | 4,175,564.98 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 85,980.58 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 85,980.58 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **605,748,334.21** | **3,199,400,460.20** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 00.00 | 921,236,964.22 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 00.00 | 892,636,964.22 |
| 225011 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 00.00 | 28,600,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | 00.00 | -921,236,964.22 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **605,748,334.21** | **2,278,163,495.98** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,685,079,443.08** | **4,007,279,997.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,685,079,443.08** | **4,007,279,997.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,377,039,500.00 | 3,846,544,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,377,039,500.00 | 3,846,544,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 308,039,943.08 | 160,735,797.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 220,895,713.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,332,610.00 | 64,255,272.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 37,811,620.08 | 96,480,525.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,629,780,768.08** | **4,007,279,997.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,629,780,768.08** | **4,007,279,997.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,570,300,067.50** | **3,995,849,732.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,808,293,000.00 | 3,331,698,575.62 |
| 210101 | Үндсэн цалин | 1,806,059,700.00 | 1,989,996,775.62 |
| 210102 | Нэмэгдэл | 811,240,500.00 | 1,200,998,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 190,992,800.00 | 13,639,700.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 127,063,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,791,700.00 | 66,190,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,403,800.00 | 14,743,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 165,000.00 | 173,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 82,400.00 | 88,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 82,500.00 | 3,191,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 58,058,000.00 | 47,993,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 234,984,500.00 | 217,519,825.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 94,968,565.25 | 90,016,181.14 |
| 210302 | Түлш, халаалт | 121,941,379.15 | 100,099,182.44 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,074,555.60 | 27,404,461.42 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 73,715,605.00 | 10,822,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,484,300.00 | 1,366,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,087,810.00 | 2,235,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,775,900.00 | 772,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 12,999,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,254,800.00 | 3,013,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,113,795.00 | 3,435,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 144,989,000.00 | 173,783,171.40 |
| 210502 | Хоол, хүнс | 144,989,000.00 | 173,783,171.40 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 148,706,218.00 | 45,956,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 148,706,218.00 | 45,956,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 39,383,338.00 | 36,682,800.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 17,378,316.00 | 36,682,800.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 22,005,022.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 44,079,881.50 | 106,034,960.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,013,900.00 | 96,587,560.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,850,647.50 | 6,358,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 803,000.00 | 799,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 865,600.00 | 130,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,546,734.00 | 2,159,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,356,825.00 | 7,160,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,891,501.00 | 1,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,465,324.00 | 6,160,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **59,480,700.58** | **11,430,264.98** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 59,394,720.00 | 7,254,700.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 7,054,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 59,394,720.00 | 200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 4,175,564.98 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 4,175,564.98 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 85,980.58 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 85,980.58 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **55,298,675.00** | **00.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **55,298,675.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **55,298,675.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 55,298,675.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 55,298,675.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-55,298,675.00** | **00.00** |

| | | | |
|---|---|---|---|
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **768,679,288.10** | **669,735,452.56** | **6,431,388,184.37** | **7,869,802,925.03** |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 605,748,334.21 | 605,748,334.21 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **768,679,288.10** | **669,735,452.56** | **7,037,136,518.58** | **8,475,551,259.24** |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 2,278,163,495.98 | 2,278,163,495.98 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **768,679,288.10** | **669,735,452.56** | **9,315,300,014.56** | **10,753,714,755.22** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,846,544,100.00 | 3,842,885,675.02 | 3,658,424.98 | 99.9 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,846,544,100.00 | 3,842,885,675.02 | 3,658,424.98 | 99.9 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,839,289,400.00 | 3,835,630,975.02 | 3,658,424.98 | 99.9 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,331,862,900.00 | 3,331,698,575.62 | 164,324.38 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 1,990,161,000.00 | 1,989,996,775.62 | 164,224.38 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 1,200,998,700.00 | 1,200,998,700.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,639,700.00 | 13,639,700.00 | - | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 127,063,500.00 | 127,063,400.00 | 100.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,190,700.00 | 66,190,700.00 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,743,800.00 | 14,743,800.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 173,300.00 | 173,300.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 88,900.00 | 88,900.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,191,500.00 | 3,191,500.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 47,993,200.00 | 47,993,200.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 210,721,700.00 | 210,721,700.00 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 97,618,300.00 | 90,016,181.14 | 7,602,118.86 | 92.2 |
| 210302 | Түлш, халаалт | 94,538,500.00 | 100,099,182.44 | (5,560,682.44) | 105.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,564,900.00 | 20,606,336.42 | (2,041,436.42) | 111.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,217,800.00 | 8,217,800.00 | - | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 996,400.00 | 996,400.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 772,600.00 | 772,600.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,013,100.00 | 3,013,100.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,435,700.00 | 3,435,700.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 143,397,900.00 | 143,397,899.40 | 0.60 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 143,397,900.00 | 143,397,899.40 | 0.60 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 45,957,000.00 | 45,956,900.00 | 100.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 45,957,000.00 | 45,956,900.00 | 100.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,381,400.00 | 29,447,400.00 | (66,000.00) | 100.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,000,000.00 | 20,000,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 6,292,100.00 | 6,358,100.00 | (66,000.00) | 101.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 799,300.00 | 799,300.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 130,700.00 | 130,700.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 2,159,300.00 | 2,159,300.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,560,000.00 | 0.00 | 3,560,000.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,560,000.00 | 00.00 | 3,560,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7254700.00 | 7254700.00 | - | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,254,700.00 | 7,254,700.00 | - | 100.0 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 7,054,700.00 | 7,054,700.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 200,000.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,846,544,100.00 | 3,846,544,100.00 | - | 100.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,846,544,100.00 | 3,846,544,100.00 | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,846,544,100.00 | 3,846,544,100.00 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 105.00 | 99.00 | 6.00 | 94.3 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 100.00 | 96.00 | 4.00 | 96.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 04.00 | 02.00 | 2.00 | 50.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **160,218,757.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **160,218,757.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **160,218,757.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **6,798,125.00** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,798,125.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,605,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 370,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,235,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **30,385,272.00** |
| 210502 | Хоол, хүнс | 30,385,272.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **36,682,800.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 36,682,800.00 |

| | | |
|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **76,587,560.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 76,587,560.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7160000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,160,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **160735797.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **160,735,797.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 64,255,272.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 96,480,525.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “..*гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах”* гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь үйл ажиллагааны зорилгоо: “*Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино”* гэж тодорхойлж, дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Хамтын удидлага- Хамтын хариуцлага;
- Ажлын байран дээрх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй стандартыг хангаж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах.

Цахим дэлгүүрт байршсан бараа мах, хүнсний ногоог бусад этгээдээс худалдан авч, 67,362.0 мянган төгрөг зарцуулсан байна.

## 4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 67,362.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтад нийцсэн, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**5. Дараагийн аудитаар анхаарах асуудал:**

**ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар:**

Онцгой байдлын байгууллагын оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулах журмыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчид шагнал олгох” журамд нийцүүлэн баталж мөрдүүлээгүй байна.

## 6. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,014.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 20,014.7 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитаар нийт 69,618.1 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 8,605.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 37,339.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 23,672.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 69,618.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,967.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн, төсвийн гүйцэтгэлийн тайланд нормативт хоолны зардлыг 20,014.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. | 1 | 20,014.7 | | | 1 | 20,014.7 | 1 | 20,014.7 | | | | |
| **Дүн** | **1** | **20,014.7** | | | **1** | **20,014.7** | **1** | **20,014.7** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Улирлын үр дүнг үнэлсэн урамшуулалтай давхцуулан архивын үзлэгийн ажлын хэсэгт, оны шилдэг эмэгтэйчүүдийн зөвлөлд, ойн баярын, балансын, улсын чанартай бөхийн барилдаанд оролцсон зэрэгт шагнал урамшууллыг хайвтгайруулан бүхий 5 алба хаагчид 8,050.9 мянган төгрөг илүү олгосон байна. | 1 | 8,050.9 | 1 | 8,050.9 | | | | | | | | |
| Хүрэл-Од ХХК-ийн гэрээт ажлын хөлсөнд нэмж олгосон 554.6 мянган төгрөгийн шатахууныг суутган тооцоогүй байна. | 1 | 554.6 | 1 | 554.6 | | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй Хүрэл-Орд ХХК- тай гэрээ байгуулж, халиа дошингийн хор уршиг арилгах, бохир ус соруулах ажилд 37,339.7 мянган төгрөгийн машин механизмын тээврийн зардал гаргасан байна. | 1 | 37,339.7 | | | 1 | 37,339.7 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгаврын хэрэгжилтийг хангаагүй 2,186.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авсан байна. | 1 | 2,186.1 | | | | | 1 | 2,186.1 | | | | |
| Дээд газрын даргын шийдвэрээр оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулсан шийдвэр нь эрх бүхий байгууллагын тогтоосон хувь хэмжээнээс үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн 20,670.0 мянган төгрөгөөр илүү олгосон байна. | 1 | 20,670.0 | | | | | 1 | 20,670.0 | | | | |
| Төсвийг зөв зохистой удирдаагүй, цалингаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг 549.7 мянган төгрөгөөр илүү төлж, авлагын үлдэгдэлтэй байна. | 1 | 549.7 | | | | | 1 | 549.7 | | | | |
| Төсвийг зөв зохистой удирдаагүй, жилийн төсөвтөө багтаан 267.1 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна. | 1 | 267.1 | | | | | 1 | 267.1 | | | | |
| **Дүн** | **7** | **69,618.1** | **2** | **8,605.5** | **1** | **37,339.7** | **4** | **23,672.9** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим дэлгүүрт байршсан бараа, мах, хүнсний ногоог бусад этгээдээс худалдан авсан байна. | 1 | 67,362.0 | | | 1 | 67,362.0 | | |
| **Нийт дүн** | **1** | **67,362.0** | | | **1** | **67,362.0** | | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2026 оны 02 дугаар сарын 25 № 07/А0210181 Улаанбаатар хот

НТАГ-2026/555/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улирлын үр дүнг үнэлсэн урамшуулалтай давхцуулан архивын үзлэгийн ажлын хэсэгт, оны шилдэг эмэгтэйчүүдийн зөвлөлд, ойн баяр, балансын, улсын чанартай бөхийн барилдаанд оролцсон зэрэг шагнал урамшууллыг хавтгайруулан нэр бүхий 5 алба хаагчид 8,050,900.00 (*найман сая тавин мянга есөн зуу*) төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*",16.5.2-т "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*" заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий 5 алба хаагчдад шагнал урамшуулал давхардуулан илүү олгосон 8,050,900.00 (***найман сая тавин мянга есөн зуу***) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ. хүү торгуулийн орлогын MN440090 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

1420110015

2.Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга М.Мягмар-Очир, ахлах нягтлан бодогч Ж.Өнөржаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 дугаар сарын 25 № 08/А0270181 Улаанбаатар хот

НТАГ-2026/555/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Хүрэл-Од" ХХК-ийн гэрээт ажлын хөлсөнд нэмж олгосон 554,600.00 (*таван зуун тавин дөрвөн мянга зургаан зуу*) төгрөгийн шатахууныг суутган тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "*анхан шатны баримт*" *гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог*", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" заасаныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "*бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн*" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Гэрээт ажлын хөлсөнд шатахуун нэмж олгоод, суутган тооцоогүй 554,600.00 (*таван зуун тавин дөрвөн мянга зургаан зуу*) төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ. хүү торгуулийн орлогын MN440090 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга М.Мягмар-Очир, ахлах нягтлан бодогч Ж.Өнөржаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН[1]:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1428110Р12

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 51/А0270181 Улаанбаатар хот

НТАГ-2026/558/НА-СТА-ТШ3

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй "Хүрэл-Орд" ХХК-тай гэрээ байгуулж, халиа, дошингийн хор уршиг арилгах, бохир ус соруулах ажилд 37,339,700.00 (*гучин долоон сая гурван зуун гучин есэн мянга долоон зуу*) төгрөгийн машин механизм тээврийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй компаниар ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, төсөв хөрөнгө зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх. Биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга ( М.Мягмар-Очир ), ахлах нягтлан бодогч ( Ж.Өнөржаргал ) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

1420990174

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 32/А0270181 Улаанбаатар хот

НТАГ-2026/558/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Цахим дэлгүүрт байршсан бараа бусад этгээдээс худалдан авч, 67,361.978.00 (*жаран долоон сая гурван зуун жаран нэгэн мянга есөн зуун далан найм* ) төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "*Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно*" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх. Биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга ( М.Мягмар-Очир ), ахлах нягтлан бодогч ( Ж.Өнөржаргал ) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

1429990133